

ДЭМБ-хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ

WHODAS 2.0

А.БАЛЖИННЯМ
Дотоодын зөвлөх

ДЭМБ-Хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ (WHODAS 2.0)

Зорилго:

1. WHODAS үнэлгээний тухай, ач холбогдол, хэрэглээ
2. Үйл ажиллагаа, оролцооны түвшинг сайжруулах хүрээнд туршиж үзэх, ашиг холбогдлын талаар тунгаан бодох

ДЭМБ-Хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ

- Хүний эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийг үнэлэх ерөнхий арга
- Бүх өвчний үед хэрэглэдэг (танин мэдэхүй, мэдрэл, донтох өвчин орно)
- Богино, энгийн хялбар (5—20 минут)
- Эмнэлзүй болон энгийн нөхцөлд аль алинд нь хэрэглэдэг
- Хөгжлийн бэрхшээлийн түвшин, стандартыг тогтоох хэрэгсэл
- Өөр өөр ёс заншилтай, насанд хүрсэн бүх хүнд хэрэглэх боломжтой

WHODAS 2.0 ба ICF

- Хүний амьдралын үе шат, үйл ажиллагааны түвшинтэй холбоотой
- ICF-ийн үйл ажиллагаа болон оролцоо гэсэн хэмжигдэхүүнтэй тохирдог
- WHODAS 2.0 нь олон улсын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны дүнд боловсруулагдсан

WHODAS 2.0

Үйл ажиллагааны түвшинг үнэлэх 6 үндсэн хэсэгтэй.

- Танин мэдэхүйн чадвар
 - ойлгох & харилцах
- Хөдөлгөөний чадвар
 - хөдөлгөөн & орчиндоо хөдлөх
- Өөртөө үйлчлэх чадвар
 - ариун цэвэр, хувцаслах, хооллох болон ганцаараа байх
- Бусадтай зохицох чадвар
 - бусад хүмүүстэй харилцах
- Өдөр тутмын амьдрал/үйл ажиллагаа
 - гэр орны ажил, соёл олон нийтийн ажил, хөдөлмөр эрхлэлт & сургууль
- Оролцоо
 - олон нийтийн үйл ажиллагаанд оролцох

WHODAS 2.0

- **2 хувилбартай:**
 - Үйлчлүүлэгч өөрөө бөглөх
 - ярилцах эсвэл
 - асран хамгаалагч бөглөх боломжтой
- **36- асуулттай хувилбар:** 20 минут зарцуулна
- **12- асуулттай хувилбар:** 5 минут зарцуулна
 - Зөвхөн үйл ажиллагааны чадварыг үнэлнэ

Аргачлал

Өөрөө хийх:

- Үйлчлүүлэгч өөрөө бөглөж болно

Ярилцлага хийх:

- Нүүр тулж эсвэл утсаар ярилцаж болно.

Итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж хийх: (үйлчлүүлэгчтэй ойр дотно хүн байх)

- Заримдаа тохиолдолд гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, бусад ажиглагч байх

Үнэлгээ

Энгийн: зүйл тус бүрийн оноог нэмнэ

- Цаг хугацаа бага зарцуулна

Нийлмэл : онолд суурилсан онооны аргаар тооцно

- Зүйл тус бүрд бэрхшээлийг түвшинг тус тусад нь кодлож тооцно
- Оноо тус бүрийг бэрхшээлийг түвшингээр нь ялгвартайгаар тогтооно
- Оноог 0-100 оноонд хувиргаж тооцно (0-бэрхшээлгүй, 100- бүтэн бэрхшээлтэй)

Хэрэв Та энэ WHODAS2.0-ийг хэрэглэх бол ДЭМБ руу хүсэлт илгээж зөвшөөрөл авна

Дадлага хийх

1 _____ 2 _____ 3 _____ 4 _____ 5 _____

1 = бэрхшээлгүй

2 = бага зэрэг

3 = дунд зэрэг

4 = их

5 = маш их/ эсвэл хийж чадахгүй

Анхаарах зүйл

- Энэ асуумжид орчны хүчин зүйлс болон туслах бүтээгдээхүний талаар тусгагдаагүй
- Иймд үйлчлүүлэгчдээ энэ талаар эхлээд хэлсэн байх. Туслах бүтээгдэхүүн хэрэгтэй байсан ч хариулах хэрэгтэй сануулах
- Тайлбар
 - Бэрхшээл: илүү их хүчин чармайлт гаргах, өвдөх, удаан хийх, хийх аргаа өөрчлөх

Дүгнэлт: та WHODAS 2.0 хэрэглэснээр тухайн үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, оролцооны түвшинг тодорхой хугацаанд харьцуулан үзэж, дүгнэлт өгөх боломжтой болно.

Даалгавар:

- Та энэхүү асуумжийг ашиглан 1-2 хүнтэй ярилцаж, асуумж авах
- Танай байгууллагаар үйлчлүүлээд гарсан хүнтэй утсаар ярилцаж асуумж авах
- Бидэнтэй сэтгэгдэлээ хуваалцана уу

Ач холбогдол

- Та энэ асуумжийн талаар мэдлэгтэй болно
- Үйл ажиллагаа, оролцоог сайжруулах зорилгын талаар боддог болох, бие сэтгэц нийгмийн загвар: үйл ажиллагаа, оролцоо сайжирах нь таны амжилт
- Үйлчлүүлэгчдэд үйл ажиллагаа, оролцооны зорилгын талаар ойлгоход туслана (эмгэгийн талаар бус)

Анхаарал хандуулсанд баярлалаа